

Монгол дахь ажилгүйдлийн төлөв байдал, хандлага

Х. Одгэрэл

Монгол Улсын Статистикийн

Төв Газрын дэс түшмэл

Монгол оронд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн системийн үед бүх нийтийн албан хөдөлмөр эрхлэлтийн механизм үйлчилж байсан бөгөөд "ажилгүйдэл" гэсэн нэр томъёо категорийг хэрэглэж байсангүй. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж буй шилжилтийн үед гадаад дотоод олон хүчин зүйлээс шалтгаалан эдийн засгийн хямрал гүнзгийрч хөдөлмөрчдийн амьжиргааны түвшин огцом буурсан зэрэг нь зах зээлийн жам ёсоор ажилгүйдэл үүсэхэд хүргэсэн.

Ажилгүйдлийн түвшин ихсэнэ гэдэг нь бүх төрлийн нөөцийн ашиглалт муудаж, хүн амын орлогын түвшин буурна гэсэн үг. Энэ нь нийгмийн бүхий л хүрээний асуудлыг хурцатган, нийгмийн болон гэр бүлийн амьдралд бухимдал төрүүлдэг. Ийнхүү ажилгүйдэл нь манай нийгмийн зангилаа асуудлын нэг болжээ.

Зохион байгуулалттай хөдөлмөр эрхлээгүй хүн 1990 онд 45,7 мянга байсан бол жил бүр өссөөр 1995 оны эцэст 217,7 мянгад хүрч, тэдгээрийн 45,1 мянга нь төв, орон нутгийн хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй эрж буй ажилгүйчүүд байна.

Монголд сүүлийн жилүүдэд ажилгүйдэл огцом хурдацтай өссөн нь:

1. Эдийн засгийн хямрал, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны огцом уналт
2. Өмч хувьчлах явцад олон хүнийг орон тоогоор цомхотгосон
3. Зээл тусалцаанд тулгуурлаж хийгдэж байсан хөрөнгө оруулалт үндсэндээ зогссон
4. Сургуульд суралцагсдын тоо цөөрсөн
5. Цэрэгт алба хаах хугацаа болон хүний тоог цөөлсөн
6. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед бэлтгэгдсэн зарим мэргэжлийн хүмүүс зах зээлийн эдийн засгийн хэрэгцээг хангахаа больсон
7. Ажиллаж байгаа хүний амьжиргааны түвшин өсөөгүй
8. Ажлын байр бий болгох хөрөнгийн эх үүсвэр багассантай холбоотой.

Сүүлийн жилүүдэд (1991–1995) хөдөлмөрийн нөөцөд ажилгүйчүүдийн эзлэх хувь 5.5–аас 4,1 хүртэл буурч, эдийн засгийн идэвхтэй хүн амаар тооцвол ажилгүйдлийн түвшин 6.5 хувиас 5.4 хувь болж буурлаа. Энэ нь эдийн засгийн байдал харьцангуй тогтворжиж зарим зогссон томоохон үйлдвэрийн газрууд үйл ажиллагаагаа сэргээн, нэг үеэ бодвол хүмүүс амьдрах аргаа олж хувиараа хөдөлмөр эрхлэж, худалдаа наймаа хийх болсон зэрэг нь өөрөө өөрстөө ажлын байр олж байгаа сайн талтай ч сөрөг үр дагавартай юм. Тухайлбал эдгээр хүмүүс татвараас зайлсхийж үйл ажиллагаа явуулахаас гадна арилжаа наймаа нь найдвартай биш учраас хэдийд ч ажилгүйчүүдийн эгнээнд шилжиж болох талтай. Дээр дурдсан хөдөлмөр эрхлээгүй байгаа 217.7 мянган хүний зөвхөн 45.1 мянга нь хөдөлмөрийн биржид бүртгүүлж ажил идэвхтэй хайж байгаа бол үлдсэн 192.6 мянга нь хэдийд ч ажилгүйчүүдийн эгнээнд шилжихэд бэлэн байна гэсэн үг. (Хүснэгт 1.1–ийг үз) Ажилгүйчүүдийн 1995 оны жилийн эцсийн мэдээнээс үзэхэд нийт ажилгүйчүүдийн 52.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Боловсролын байдлаар нийт ажилгүйчүүдийн 2.6 хувь нь дээд боловсролтой, 15.4 хувь нь колледж төгссөн болон тусгай дунд боловсролтой, 22.8 хувь нь сургалт үйлдвэрлэлийн төв төгссөн, 22.8 хувь нь мэргэжилтэй ажилчид 59.2 хувь нь мэргэжилгүй болон ЕБС–ийн сургууль төгссөн хүмүүс байна. (Хүснэгт 1.2–ыг үз)

Хүснэгт 1.1 Ажилгүйдлийн түвшин.

	1991	1992	1993	1994	1995
Ажилгүйчүүдийн тоо	55407	54042	71912	74881	45107
ХН-д эзлэх хувь	5.5	5.1	6.6	6.9	4.1
ЭЗИХА-д эзлэх хувь	6.5	6.3	8.5	8.7	5.4

Мэдээллийн эх үүсвэр: УСТГ-ын 1995 оны эмхтгэл

Хүснэгт 1.2 Ажилгүйчүүд боловсролоор, 1991-1995

	1991	1992	1993	1994	1995	хувь	95/94
Бүгд	55407	54042	71912	74881	45107	100	60.2
эмэгтэй	31254	28924	38415	40239	23605	52.3	58.7
дээд	1428	729	1207	1460	1194	2.6	81.8
коллежд	—	—	—	915	949	2.1	103.7
тусгай дунд	3763	3431	5606	6088	5992	13.3	98.4
ЕБС	—	—	—	11202	14512	32.3	129.5
МСТ төгссөн	11027	12487	16140	18535	10304	22.8	55.5
мэргэжилгүй	—	—	—	36681	12156	26.9	33.1
бусад	39189	37395	48959	—	—	—	—

Мэдээллийн эх үүсвэр: УСТГ-ын мэдээ.

Эндээс харахад мэргэжилгүй ба мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшиж чадаагүй дадлага, туршлага багатай шинэ залуу ажилчид, эмэгтэйчүүд ажилгүйдэлд их өртөж байна.

Хүснэгт 1.3 Ажилгүйчүүдийг ажилгүй болсон шалтгаанаар.


	1991	1992	1993	1994	1995	хувь	95/94
анх удаа ажил эрж байгаа	—	—	—	13052	9764	21.6	74.8
тайлант сард нэмэгдсэн	5392	3654	4088	4654	5411	100	116.3
орон тооны цомхотгол	1251	464	1893	727	812	15.0	111.7
ЗХГ-аас суллагдсан	126	23	55	27	70	1.3	259.3
өөр газраас шилжиж ирсэн	860	377	615	463	489	9.0	105.6
цэргээс халагдсан	—	—	—	539	378	7.0	70.1
бусад	3155	2760	1525	2898	3662	67.7	25204 7376

Мэдээллийн эх үүсвэр: УСТГ-ын мэдээ

Нийт ажилгүйчүүдийн 21.6 хувь нь анх удаа ажил эрж байгаа хүмүүс байна. Шинээр бүртгүүлсэн ажилгүйчүүдийн хувьд шилжилтийн үеийн эхний жилүүдэд орон тооны цомхотгол, байгууллага татан буугдсан шалтгаан зонхилж байсан бол 1995 оны 1 сарын 1-ны байдлаар нийт ажилгүйчүүдийн 15.0 хувь орон тооны цомхотголоор, 1.3 хувь нь ЗХГ-аас суллагдсан, 9.1 хувь нь шилжин ирсэн, 6.9 хувь нь цэргээс халагдсан, 67.7 хувь нь бусад зэрэг шалтгаанаар бүртгэгдсэн байна. (хүснэгт 1.3-ыг үз.)

10000 хүн амд ногдох ажилгүйчүүдийн тоогоор Дорнод, Говь-Алтай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Дорноговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Ховд, Хэнтий, Говь-сүмбэр аймгууд улсын дунджаас дээгүүр байна. Харин Дундговь, Өмнөговь, Төв, Увс, Хөвсгөл, Дархан-уул, УБ, Орхон аймгууд улсын дунджаас (193,27) бага байна. (График 1-г үз)

График 1



Мэдээллийн эх үүсвэр: УСГ-ын эмхтгэл 1995


Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай, хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлэн ажил идэвхтэй хайж байгаа иргэдийг ажилгүйчүүд гэнэ гэсэн олон улсын стандартыг манай оронд баримталж байна. Ажилгүйдлийн мэдээг сар бүр Улсын Статистикийн Газарт аймаг, дүүргээс мэдээлдэг боловч ажилгүйчүүдийн талаархи мэдээ нь дутуу дулимаг бөгөөд тэдгээрийн бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлж судалгаа шинжилгээнд ашиглахад бэрхшээлтэй байдаг тул ажилгүйчүүдийн талаар авдаг мэдээний асуудлыг өөрчилж оновчтой, дэлгэрэнгүй болгох хэрэгтэй байна. Тухайлбал ямар ажил хаана, хэдийнээс хийх сонирхолтой байна хэр удаан ажилгүй байна, орлогын эх үүсвэртэй юу, ам бүлийн тоо, мөн насаар нь ангилсан мэдээллийг авах шаардлагатай юм.

Ажилгүйдэл их байгаа нь нийгмийн хуримтлал багасах, ядуучуудын тоо нэмэгдэх, сахилга дэг журам алдагдан гэмт хэрэг зөрчил өсөх нэг үндэс болж

байна. Сүүлийн 5 жилд гэмт хэрэгт холбогдсон 64,4 мянган хүний 44,9 хувь нь ажил, сургуульгүй байжээ.

Жишээлбэл: ХАБХЯ-наас 1995 онд явуулсан улсын үзлэгээр ажилгүйчүүдийн мэдээллийг нэлээд оновчтой дэлгэрэнгүй маягаар авсан байна. Эндээс үзэхэд Ажилгүйчүүдийн 65.25 хувь нь ажил олддоггүйгээс, 13.1 хувь нь мэргэжилгүйгээс шалтгаалсан (График 2) бөгөөд нийт ажилгүйчүүдийн 16,8 хувь нь 7-12 сараар, 27.2 хувь нь 13-24 сараар, 41.3 хувь нь 25 ба түүнээс дээш сараар ажил хайж байгаа юм байна. (График 3-аас үз)

График 2.



Мэдээллийн эх үүсвэр: УСГ-ын эмхтгэл 1995

График 3



Мэдээллийн эх үүсвэр: УСГ-ын эмхтгэл 1995

Ажилгүйчүүдийг орлогын байдлаар авч үзэхэд ажилгүйчүүдийн 82.7 хувь нь АБДТ-ээс бага орлоготой байна.(хүснэгт 1.4-аас үз)

Хүснэгт 1.4

Ажилгүйчүүд	Өрхийн дундаж орлого		Өрхийн нэг гишүүнд ногдох орлого	
	6400 төг хүртэл	6400-аас дээш	АБДТ хүртэл	АБДТ-ээс дээш
Бүгд	42061	35595	6466	34796
42061	35595	6466	34796	7265

Улсын үзлэгийн мэдээнээс дүгнэлт хийхэд:

1. Үзлэгийн үед хөдөлмөр эрхлээгүй 146,1 мянган хүнээс хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 42,1 мянга байгаа нь анхаарал татаж байна.

Тиймээс хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо буурлаа гэж үзэж болохгүй бөгөөд ажилгүйчүүдийн бүртгэл мэдээг оновчтой үнэн зөв болгож далд ажилгүйдлийг шийдвэрлэхэд ихээхэн анхаарал төвлөрүүлэх шаардлагатай байна.

2. Ажилгүйчүүдийг насны байдлаар үзэхэд 51,7 хувь нь 18-34 насны залуучууд мөн боловсролын байдлаар авч үзэхэд 85,7 хувь нь ЕБС-ийн төгссөн хүмүүс байгаа нь ажилгүйдэлд залуучууд их өртөж байгааг харуулж байна. Жил тутам ЕБС болон мэргэжлийн сургуулийг 50-60 мянган хүн төгсөж байгаа боловч тэр хэмжээгээр ажлын байр шинээр бий болгож чадахгүй байгаатай холбоотой.

3. Ажилгүйчүүдийн 52,4 хувь нь мэргэжилгүй хүмүүс байна.Ийм хүмүүст мэргэжил эзэмшүүлэхийн тулд сургалт зохион байгуулж мөн хөдөлмөр зарцуулалт ихтэй, олон хүн ажиллах шаардлагатай ажлын байр санаачлах нь (газар тариалан,МАА эрхлэх, болон зам гүүр тавих г,м) чухал.

4. Ажилгүйчүүдийн 65.3 хувь нь ажил олддоггүй учраас ажилгүй байгаа гэсэн нь хөдөлмөр зохицуулалтын албанд сул ажлын байрны мэдээ ирдэггүй буюу хангалтгүй байгаатай холбоотой. Иймээс энэ талаархи мэдээг ХЗА-нд ирүүлж байхын тулд үйл ажиллагааг нь сайжруулах, хот, хөдөөгийн ХЗА-ыг холбосон сүлжээг даруй бий болгох шаардлагатай байна.

5. Ажилгүйчүүдийн нэлээд хэсгийн ажилгүй байгаа хугацаа нь урт ө.х 25 ба түүнээс дээш сар байна. Энэ нь манайд урт хугацааны ажилгүйдэл их байна гэсэн үг.. Нэг талаас хөдөө орон нутагт ажлын байрны захиалга, ажиллах хүчний хэрэгцээ бага байгаатай нөгөө талаас мэргэжил, боловсролгүй хүнийг ажилд авах сонирхол бага түүнээс гадна эдгээр хүмүүсийг дахин сургахад шаардагдах хөрөнгө санхүүгийн асуудал, ажилгүйчүүдийн идэвх сул,аж ахуй үйлдвэрлэл эрхлэх мэдлэг чадвар дутагдалтай байгаатай холбоотой. Урт хугацаагаар ажилгүй байгаа хүмүүс нийгэмд эзлэх байр сууриа алдаж гэмт хэрэг,зөрчилд өртөгдөх явдал ихсэж байна.

6. Ажилгүйчүүдийн 82,7 хувь нь ядуурлын түвшинд байна. Ийм учраас эдгээр хүмүүсийг ажлын байраар хангах,ажилгүйдлийн тэтгэмжид хамруулах нэн тэргүүний шаардлага тавигдаж байна.

Ажилгүйдэлд нөлөөлөгч хүн ам зүйн хүчин зүйлс.

1. Хүн амын өсөлт ба ажилгүйдэл

Нийгэм , эдийн засгийн өөрчлөлт нь хөдөлмөрийн нөөцийн бүтэц, ажиллах хүчний хэрэгцээг өөрчилдөг. Хэдий тийм боловч эдгээр хүчин зүйлүүд нь ажиллах

хүчний өсөлтийн 10 орчим хувийг эзэлж, бараг 90 хувь нь урьдах жилүүдийн хүн амын насны бүтцээс шалтгаалдаг байна. Хүн амын өсөлт нь 15–30 жилийн дараа ажиллах хүчний өсөлтөд нэлээд хүчтэй нөлөөлнө. Тухайлбал өндөр төрөлттэй байсан 60, 70–аад оны иргэд 80,90–ээд онд ажиллах хүчинд орж ажилгүйчүүд, ажиллагсадын бүтэц, тоонд өөрчлөлт оруулсан. (хүснэгт 2.1)

Хүснэгт 2.1

он	Хүн амын тоо (мянгаар)	Жилийн дундаж өсөлт (хувиар)	Хөдөлмөрийн нөөц (мянгаар)	ХН-ийн өсөлт хувь
1960	968.1	2.53	472,0	–
1970	1265.4	3.07	526,2	1.15
1980	1682.0	2.29	696,2	3.23
1985	1900.6	1.30	778,7	2.37
1986	1949.6	2.58	806,8	3.61
1987	1997.0	2.43	833,6	3.32
1988	2044.0	2.35	863,0	3.53
1989	2095.6	2.52	903,4	4.68
1990	2149.3	2.56	946,7	4.79
1991	2187.2	1.76	1003.6	6.01
1992	2215.0	1.27	1059.9	5.60
1993	2250.0	1.58	1080.9	1.98
1994	2280.0	1.33	1089.3	0.77
1995	2317.5	1.64	1103.1	1.27

Мэдээллийн эх үүсвэр: 1995 оны эмхтгэл


Ийнхүү хүн ам өсөхөд хөдөлмөрийн насны хүн амын хэмжээ нэмэгдэж энэ өсөлтийг ажлын байрны өсөлт гүйцэж чадахгүйгээс болж ажилгүйдэл үүсдэг. Үүнийг "Хүн ам зүйн ажилгүйдэл" гэж нэрлэдэг.

Хүн амын өсөлтөөс хөдөлмөрийн насны хүн амын өсөлт түрүүлж өсөж байгааг график 4–өөс харж болно.

60,70–аад онд өндөр төрөлттэй үеийн иргэд 80, 90–ээд онд хөдөлмөрийн насанд шилжин орж эдүгээ хүн амын хүн амын залуужилтын үйл явц оргил үедээ хүрсэн бөгөөд түүний гол онцлог шинж гэвэл хүн амын өсөлтөөс хөдөлмөрийн нөөцийн өсөлт, залуу үеийн хэмжээнд хүүхдийн өсөлтийг залуучуудынх, айл гэрийн хувьд гэрлэлт, төрөлтийн насныханы түргэн өсөлтийг гэрлэгч хосын тоо, шинэ гэрийн төхөөрөлт, орон сууцны барилгажилт гүйцэхээ больсонд оршино.

Хүн ам зүйн ажилгүйдэл нь цаашид нэмэгдэх төлөвтэй. Учир нь 1995 оны байдлаар хүн амын өсөлт 1,64 байхад хөдөлмөрийн нөөцийн өсөлт 2,2 орчим, гэтэл ажлын байрны өсөлт 0,7 орчим байна.

график 4




Мэдээллийн эх үүсвэр 1995 оны Хөдөлмөрийн нөөцийн баланс.

2. Хотжилт ба ажил эрхлэлт, ажилгүйдэл


Эдийн засгийн хөгжилд хотжилт чухал үүрэг гүйцэтгэж ирснийг түүхээс харж болно. Хот нь үйлдвэрлэл, үйлчилгээний төв болж газар тариалан, мал аж ахуйгаас илүү их ашиг олж, үүгээрээ эдийн засаг нь хүн амтайгаа цуг хөгжих бололцоо үүсгэдэг. Гэвч хотжилт нь үүний зэрэгцээ бусад олон асуудлын эх үүсвэр болдог байна. Хотын хурдацтай өсөлт нь хүн амыг хэт төвлөрүүлэх, үйлчилгээ муудах, гэр оронгүй хүмүүсийн амьдрах жижиг сууринг олшруулж, ажилгүйдэл, гэмт хэрэг ихсэх, мөнгөний ханшны уналтыг хөөрөгдөж өгдөг гэх мэт олон сөрөг үр дагаварыг бий болгодог. Хотын талаархи асуудалд хүн амын хурдацтай өсөлтийг хамааруулахад хотжилт (нийт хүн амд хотын хүмүүсийн эзлэх хувь График 5), хотын өсөлт (хотын хүн амын өсөлт График 6) хоёрыг ялган гаргах нь чухал. Нийт хүн амд хотын хүмүүсийн эзлэх хувь жилээс жилд өсөх хандлагатай байна. 1994 оны байдлаар нийт хүн амын 54,63 орчим хувийг хотын хүн ам эзэлж байна.

График 5.



Мэдээллийн эх үүсвэр: УСГ-ын эмхтгэл 1995

график 6



Мэдээллийн эх үүсвэр: УСГ-ын эмхтгэл 1995

Нэг талаас ихэнх үйлдвэрийн газрууд орчин үеийн хөдөлмөр хөнгөвчилсөн технологитой учраас заавал мэргэжил, боловсролтой ажиллах хүчнийг шаардаж, нөгөөтэйгээр ажилгүйчүүдийн ихэнх нь боловсрол, мэргэжилгүй байгаа учраас эдгээр хүмүүсийг ажлын байраар хангаж чадахгүй байна. Үүний уршгаар хотын хөдөлмөрийн зах зээлийг илүү зохион байгуулагдсан буюу илүү хөлс авдаг нэг хэсэг, ажил олдохгүй бага хөлстэй "жирийн" ажилчид (гэрийн цэвэрлэгч, гудамж цэвэрлэгч гэх мэт) гэсэн 2 хэсэгт хуваагдах төлөвтэй.

Ажилгүйдлийг бууруулах шаардлага.

Ажилгүйчүүдийн тоо өсөж байгаа нь нийгмийн хуримтлал багасах, ядуучуудын тоо нэмэгдэх, сахилга дэг журам алдагдан гэмт хэрэг, хэв журмын зөрчил нэмэгдэх нэг үндэс болж байна. Үүнийг дараах хэдэн үзүүлэлтүүдээр тайлбарлаж болох юм.

1. ҮНБ-ний бууралт ба ажилгүйдэл.

Нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүн 1990-1995 оны хооронд 18 хувиар, дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 22 хувиар тус тус буурчээ. / Хүснэгт 4.1/ Ажилгүйдлийн түвшин эрс буурсан 1995 онд нэг хүнд ногдох ҮНБ өмнөх оноосоо 4,9 хувиар өсчээ.

Хүснэгт 4.1

Үндэсний нийт бүтээгдэхүүн ба ажилгүйдлийн түвшин.
(1993 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөгөөр)

	1990	1991	1992	1993	1994	1995
ДНБ	208641,9	189349	171365,4	166219,1	170042	180775,4
1 хүнд ногдох	100526	88938	78713	74830	75273	78807
ҮНБ	186802,4	180919	166923,4	154640,1	159434	169797,1
1 хүнд ногдох	90004	84979	76672	69617	70577	74021
АТ	5,7	6,5	6,3	8,5	8,7	5,4

АТ-ажилгүйдлийн түвшин. Мэдээллийн эх үүсвэр: УСГ, 1995 он

2. Ядуурал ба ажилгүйдэл.

Ядууралд олон ам бүлтэй, орлого багатай айл өрхийн иргэд, өрх тэргүүлсэн эмэгтэйчүүд, тахир дутуу хүмүүс, өнчин хагас өнчин хүүхэд, залуучууд, харж хандах хүнгүй өндөр настан, ажилгүйчүүд илүү өртөж байна. Нийт ядуу өрхийн 25.3 хувь нь 16 хүртэлх насны 4-өөс дээш хүүхэдтэй, 31.9 хувь нь өрхийн ам бүлийн гишүүдээс аж ахуйн нэгж, байгууллагад ажилладаг хүнгүй өрх, 22.8 хувь нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх байна. Ялангуяа хотод үйлдвэрлэлийн уналт, ажилгүйдэл өссөнөөс хөдөлмөрийн хөлснөөс өөр орлогын эх үүсвэргүй хүмүүс ядууралд нэрвэгдэж байхад, хөдөө орон нутагт дэд бүтэц, зах зээл хөгжөөгүй, уламжлалт МАА-н ашиг шим бага зэргээс малгүй буюу цөөн малтай иргэд ядууралд орж байна.

3. Гэмт хэрэг ба ажилгүйдэл.

Ажилгүй хүмүүс нийгэмд эзлэх байр сууриа алдаж, амьдралын баталгаагүй болж гэмт хэрэг, зөрчил гаргах нь ихэсдэг. Сүүлийн 5 жилд гэмт хэрэгт холбогдсон 64.4 мянган хүний 44.9 хувь нь ажил, сургуульгүй хүмүүс байжээ.

Ажилгүйдлийг бууруулахад тохиолдож буй бэрхшээл.

Хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх, ажилгүйдлийг бууруулах талаар Засгийн газраас анхаарч хөдөлмөр зохицуулалтын алба, "Ажил эрхлэлтэд туслах сан" зэргийг байгуулж ажлын шинэ байр бий болгох санаачлагыг дэмжин хөнгөлөлттэй зээл олгох зэрэг арга хэмжээ авч байгаа боловч эдгээр байгууллагуудын үйл ажиллагаа амьдралд биелэлээ олохгүй байна. Хөдөлмөр зохицуулалтын алба байгуулагдсан ч ажилгүйдлийнхээ бүртгэлийг хагас дутуу хийхээс өөр дорвитой үйл ажиллагаа явуулахгүй байна. Уг нь хөдөлмөр зохицуулалтын алба нь ажилгүйдлийг бууруулах талаар төрөөс явуулж буй бодлогыг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, ажиллах хүчний эрэлт хангалтыг судлах, ажлын байрны захиалга авах, ажилгүй хүмүүсийг бүртгэх, тэдэнд хөдөлмөр эрхлэхэд нь зуучлан туслах, ажилгүйдлийн тэтгэмж олгох, мэргэжил эзэмшүүлэх зорилготой.

Ажилгүйдлийг бууруулах арга зам.

Манай орны хувьд ажилгүйдэл нийгмийн тогтолцооны шилжилттэй давхцаж ил тод гарч ирсэн бөгөөд хэлбэрийн хувьд мөчлөгийн ажилгүйдэл голлож ердийн болон бүтцийн ажилгүйдэл дагалдах шинжтэй байна.

Харилцан өөр түвшинд шийдэгдэх дээрх гурван хэлбэрийн ажилгүйдлийг нэг аргаар шийдвэрлэж болохгүй. Тухайлбал, мөчлөгийн ажилгүйдэл шилжилтийн үеийн онцлогтой холбоотой учир үйлдвэрлэл ба хөрөнгө оруулалтыг дэмжих замаар ажлын байр бий болгох хэрэгтэй.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 50 хувь нь ямар ч боловсрол, мэргэжилгүй хүмүүс байгаа. Ийм хүмүүсийг ажилтай болгох асуудлыг хөрөнгө оруулалт, зээл тусламжын юмуу хөдөлмөрийн захын идэвхтэй бодлогоор шийдэж чадахгүй. Мөн эдгээр хүмүүст мэргэжил эзэмшүүлэх боломж нөхцөл байсан ч ажлын байр хангалттай биш учраас харин ч нэмээд ямарч шаардлагагүй мэргэжилтэй юмуу тодорхой хэдэн мэргэжлийн чиглэлээр нэмээд ажилгүйдэл буй болох эх үүсвэр үүсэх сөрөг талтай. Төрөөс ажилгүйчүүдийг жижиг дунд үйлдвэрлэл эрхлэхийг дэмжинэ гэж байна. Үнэн хэрэг дээрээ зээл авсан хүмүүс татвар, зээлийн хүүгийн дарамтад цохигдох гэх мэт шалтгаанаас төрөөс явуулах бодлогуудын зарим нь хэрэгжих үндэс алга гэж хэлж болмоор байна.

Манай орны нийгэм хүн ам зүйн нөхцөл байдал, өөрчлөн байгуулалтын эхэн үеийн явцаас үзэхэд ажилгүйдлийн хэмжээ ихсэх төлөвтэй байна. Иймд ажилгүйдлийг хяналтаас алдахгүйн тулд няхуур ажиллахыг шаардаж байна. Үүний тулд дараах саналуудыг дэвшүүлж байна:

1. Ажиллагчид, ажилгүйчүүд хоёроо сайтар зааглах шаардлагатай. Ажилгүй гэж бүртгүүлсэн боловч хөдөлмөрийн гэрээгүйгээр ажил эрхэлж байгаа болон худалдаа, наймаа хийж орлого олж байгаа хүмүүс нуугдмал байдалтай байна. Нэгэнт энэ хүмүүс ажил эрхэлж байгаа бол ажилгүйчүүдийн бүртгэлээс хасагдах ёстой.

2. Хүн амын статистикийг сайжруулах нь эдийн засгийн ямар ч харилцааны үед зайлшгүй байх ёстой. Энэ үүднээс хөдөлмөрийн харилцаанд судалгаа явуулж дүгнэлт гаргадаг, ажилгүйдлийг бууруулах төрөл бүрийн хувилбар боловсруулдаг эрдэм шинжилгээний байгууллага зайлшгүй хэрэгтэй байна.

3. Ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлийн олон талын судалгааны чиглэлүүдийг нэгтгэн дүгнэж түүнийг өөрийн орны онцлогийг тусгасан үндэсний үзэл баримтлалыг боловсруулан хэрэгжүүлэх

4. Оюуны хомсдолтой болон хүүхдээ өсгөх эдийн засгийн бололцоогүй хүмүүсийн дотор төрөлтийг эрс багасгах замаар оюун санаа, бие бялдарын өндөр чадвартай хүн амын өсөлтийг хангах бодлогыг баримталж, ажилгүйдлийг хэвийн төвшинд байлгах үзэл баримтлал боловсруулан төрийн зохицуулалт явуулах.

5. Гадаад, дотоодын хөнгөлттэй хөрөнгө оруулалтыг дэмжсэн бодлого явуулах,

6. Тэтгэврт гарсан боловч ажлаа үргэлжлүүлэн хийж байгаа явдлыг арилгах. Үүний тулд бүтээлч хөдөлмөрийг цаг тухайд нь урамшуулахгүй бол ажилгүйдлийг багасгаж чадахгүй.

7. Ажиллах хүчний өртгийг нэмэгдүүлэх. Энэ үнэлэмжийг өндөр болговол ажил эрэлхийлэх сонирхол дээшилнэ.

8. Ажилгүйчүүдийн дийлэнх нь мэргэжил шаардахгүй хөдөлмөрийг сонирхож байгаа, ажлын байр бий болгох хуримтлал хөрөнгө оруулалтын санхүүгийн болмж муу байгааг харгалзан хөдөлмөр зарцуулалт ихтэй технологийг тодорхой хугацаанд урамшуулах замаар ажлын байр бий болгох.

Ашигласан материал

"Ажилгүйдлийн мэдээ" УСГ 1991-1995 он

"Ажилгүйдлийг бууруулах үндэсний хөтөлбөр" 1995 он

"Population projections and labour force" International institute for population sciences . Bombay , 1994, May

"Population labour force and employment: concepts, trends and policy issues"
Grazi M.Farooq and Yaw Ofori 1992